



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/560

Эрдэнэт

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3/б/, 29.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах” аймгийн дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амыг шинэ ургацын хямд үнэтэй төмс, хүнсний ногоогоор хангах зорилгоор “Намрын ногоон өдрүүд-2017” үзэсгэлэн худалдааг 2017 оны 10 дугаар сарын 04-нөөс 2017 оны 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд “Спорт, амралтын хүрээлэн”-гийн ар талын машины зогсоолын талбайд зохион байгуулсугай.


2. “Намрын ногоон өдрүүд-2017” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг I, бэлтгэл ажлын төлөвлөгөөг II, арга хэмжээнд шаардагдах зардлыг III хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдааны бэлтгэлийг сайтар хангаж, өөрсдийн ногоочдыг өргөнөөр оролцуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр, Хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар /н.Батбаяр/ нарт үүрэг болгосугай.

4. “Намрын ногоон өдрүүд-2017” үзэсгэлэн худалдаанд шаардагдах 2732000 /Хоёр сая долоон зуун гучин хоёр мянган/ төгрөгийг “Алтан намар-2017” орон нутгийн шинэ ургацын ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажлын явц, үр дүнг танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

02000-3035

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 22-ны өдрийн
560 дугаар захирамжийн гуравдугаар
хавсралт



**“НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-2017” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ
АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/ д	Ажил арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төг/	Нийт үнэ /мян.төг/
1	Анонс хийлгэх	50 м ²	9000	450.0
2	Мандат хэвлүүлэх	80 ширхэг	2500	200.0
3	Ажлын хэсгийн малгай, эмблем хийлгэх	20 ширхэг	22000	440.0
4	Өргөмжлөл	15	30000	450.0
5	Сүүдрэвч, ширээ зөөж байрлуулах	2	75000	150.0
6	Хөгжим аппаратурыг ажиллуулах	3 өдөр	20000	60.0
7	Цахилгааны зардал	3 өдөр	-	50.0
8	Хөтлөгч	2 удаагийн арга хэмжээ	25000	50.0
9	Урлагийн номер	2 удаагийн арга хэмжээнд	30000	60.0
10	Шатахууны зардал			72.0
11	Шагналын сан /10-н үзүүлэлтээр шалгаруулах/	15 шагнал		750.0
	Нийт зардал	-	-	2732.0